



МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2016 ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал ба хөрөнгийн данс 2016 онд 609 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 812 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 18 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр буурсан. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -221 сая ам.доллар байна.

2015 оны гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 224 сая ам.доллараар буурсан, харин санхүүгийн данс 24 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант жилийн эцсийн байдлаар 1,296.4 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 5.3 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 0,7% -иар буурч 8,270 сая ам.долларт хүрсэн бөгөөд барааны худалдааны тэнцэл тайлант онд 1,338 сая ам.долларт хүрч, сүүлийн 10 улирал дараалан ашигтай гарч байна.

Үүнд 2016 онд нефтийн импорт 25%-иар, хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашины импорт 20%-иар тус тус буурсан, алт, мөнгө болон нүүрсний экспорт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн.

Үйлчилгээний худалдаа

2016 онд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 87%-иар буюу 623 сая ам.доллараар өсч 1338 сая ам.долларт хүрсэн байна.

Алдагдалын өсөлтөнд бусад үйлчилгээний зардал өмнөх оноос 587 сая ам.доллараар, (үүнд банк санхүү болон уул уурхайн салбар дахь санхүү болон бизнесийн бусад үйлчилгээний зардал голлон нөлөөлсөн) өссөн нь нөлөөлжээ.

Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 911 сая ам.долларын алдагдалтай гарч өнгөрсөн оноос 6%-иар буюу 58 сая ам.доллараар буурсан.


Тодруулбал, гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт 220 сая ам.доллар, ногдол ашигт 193 сая ам.доллар, хөрөнгө оруулагчдийн зээлийн хүүгийн төлбөрт 338 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 221 сая ам.доллар, банкууд гадаад зээл болон харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 130 сая ам.доллар төлсөн нь тус тус нөлөөлсөн байна.

Хоёрдогч орлого


Энэ дансанд хувийн гуйвуулга болон хандив тусламжийн орлогыг бүртгэдэг бөгөөд 2016 онд манай улс нийт 212 сая ам.доллар буюу өнгөрсөн оноос 38 сая ам.доллараар их орлогыг хүлээн авсан байна. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан гуйвуулга өмнөх оноос 4.6%-иар, харин гадаад руу шилжүүлсэн иргэдийн гуйвуулга 35.6%-иар тус тус буурч,
- Хандив, тусламжийн орлого өмнөх оноос 15%-иар буурсан үзүүлэлттэй байна.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл



Дүрслэл 2. Барааны худалдаа



Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 1. Хувийн гуйвуулга (улсаар, мянган ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	89,362	44% ▲	47%	8,133	10% ▼	-1%
Америк	34,476	17% ▲	33%	20,462	24% ▼	-11%
Хятад	11,181	6% ▼	-23%	14,842	18% ▼	-44%
Гонг Конг	4,567	2% ▼	-40%	1,831	2% ▼	-70%
Англи	10,145	5% ▼	-23%	3,317	4% ▼	-12%
ОХУ	4,256	2% ▼	-31%	10,898	13% ▲	70%
Сингапур	3,311	2% ▼	-25%	1,746	2% ▼	-64%
Швейцарь	916	0% ▼	-77%	191	0% ▼	-96%
Герман	6,751	3% ▼	-9%	3,371	4% ▲	1%
Япон	5,908	3% ▼	-10%	2,546	3% ▼	-8%
Бусад	30,846	15% ▼	-49%	17,382	21% ▼	-58%
НИЙТ	201,718	100%		84,718	100%	

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2016 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт 4171 сая ам.долларын алдагдалтай буюу өнгөрсөн оны гүйцэтгэлээс 4254 сая ам.доллараар буурсан үзүүлэлтэй байна. Энэ нь 3756 сая ам.долларын хөрөнгө оруулагчдийн зээлийг буцаан төлсөнтэй холбоотой байна.

Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар нь авч үзвэл,

- Англи улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оноос 154 сая ам.доллараар өсч +118 сая ам.доллар,
- Австрали улсын хөрөнгө оруулалт 135 сая ам.доллараар нэмэгдэж +17 сая ам.доллар,
- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт -3750 сая ам.доллараар буурч -3763 сая ам.доллар,
- ОХУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 399 сая ам.доллараар буурч -400 сая ам.долларын урсгалтай гарсан байна.

Эдийн засгийн салбараар нь авч үзвэл 2016 онд уул уурхай, боловсруулах салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ өнгөрсөн оны гүйцэтгэлээс буурсан дүнтэй байна.

Салбаруудын хөрөнгө оруулалтын хэмжээг харьцуулбал,

- санхүү, даатгалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө оруулалт 43 сая ам.доллараар,
- барилгын салбарын компаниудынх 39 сая ам.доллараар,
- бусад үйлчилгээний салбарынх 25 сая ам.доллараар тус тус өссөн.
- Харин уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 3,795 сая ам.доллараар,
- боловсруулах үйлдвэрийнх 411 сая ам.доллараар,
- бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарынх 55 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2016 онд 487 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 239 сая ам.доллараар өссөн байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сард гаргасан 500 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй, 5 жилийн хугацаатай, 10,875%-ийн хүүтэй Мазаалай бондын эх үүсвэртэй холбоотой байна.

Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд санхүүгийн дээрх дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд буюу бусад бүх төрлийн зээл (арилжааны, хөнгөлөлттэй, худалдааны г.м), бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

Тайлант онд бусад хөрөнгө оруулалтын данс 4534 сая ам.долларын ашигтай гарсан ба үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал тэнцэл 4079 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Энэ нь манай улсын томоохон аж ахуйн нэгжүүдийн гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн эх үүсвэрээс голлон шалтгаалжээ.

Хүснэгт 2. ГШХО, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	Жил		2016/15	
		2015	2016	Өөрчлөлт	
1	Австрали	-117.4	17.2	134.7	▲
2	Америк	25.3	39.7	14.4	▲
3	Англи	-36.0	117.6	153.6	▲
4	Бельги	1.4	-1.3	-2.6	▼
5	БНХАУ	-15.0	18.4	33.5	▲
6	Герман	-1.7	31.6	33.3	▲
7	Голланд	-22.0	-226.0	-204.0	▼
8	Гонг-Конг	246.1	94.5	-151.6	▼
9	Канад	-12.5	-3762.5	-3749.9	▼
10	Люксембург	4.1	-139.7	-143.8	▼
11	Малайз	0.3	-2.9	-3.2	▼
12	ОХУ	-1.4	-400.2	-398.8	▼
13	Сингапур	-5.6	-60.8	-55.1	▼
14	Солонгос (өмнөд)	7.8	6.9	-0.9	▼
15	Япон	24.3	67.7	43.4	▲
16	Бусад	-3.6	43.6	47.2	▲
Нийт		94.0	-4156.0	-4250.0	▼


Хүснэгт 3. ГШХО, эдийн засгийн салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	Жил		2016/15	
		2015	2016	Өөрчлөлт	
1	Барилга	43.4	82.5	39.1	▲
2	Боловсрол	1.8	0.8	-1.0	▼
3	Боловсруулах үйлдвэрлэл	18.1	-393.0	-411.1	▼
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	117.6	62.9	-54.7	▼
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	128.9	99.2	-29.7	▼
6	Мэдээлэл, холбоо	12.8	6.8	-6.1	▼
7	Мэргэлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	28.4	-10.8	-39.2	▼
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	45.5	89.0	43.5	▲
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	9.3	3.6	-5.6	▼
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	25.0	5.3	-19.7	▼
11	Уул уурхай, олборлолт	-369.2	-4164.5	-3795.3	▼
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	-20.3	4.9	25.3	▲
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	35.9	45.0	9.1	▲
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	6.6	4.9	-1.7	▼
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6.2	12.0	5.8	▲
16	Бусад	4.1	-4.7	-8.8	▼
Нийт		94.0	-4156.0	-4250.0	▲

Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт



II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2016 оны эцэст -29,353 сая ам.доллар байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат бус этгээдэд оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 4,309 сая ам.доллар байна. Үүний 51%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 30%-ийг гадаад валютын улсын нөөц, 11%-ийг шууд хөрөнгө оруулалт, 6%-ийг багцын хөрөнгө оруулалт, 2%-ийг санхүүгийн үүсмэл хэрэгслүүд тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 33,662 сая ам.долларт хүрчээ. Үүний 48%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 41%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 2.5%-иар буюу 721 сая ам.доллараар өссөн. Энэ нь

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 10.3%-иар буюу 402 сая ам.доллараар, гадаад пассив 3.5%-иар буюу 1,123 сая ам.доллараар өссөнөөр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 4,435 сая ам.доллараар, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн богино позиц 36 сая ам.доллараар тус тус буурснаар, харин багцын хөрөнгө оруулалтын богино позиц 507 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 4,658 сая ам.доллараар тус тус өссөнөөр тайлбарлагдаж байна.
- Позицийн өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн орох, гарах урсгалаар -710 сая ам.доллар, үнийн өөрчлөлтөөр 35 сая ам.доллараар, бусад өөрчлөлтөөр -610 сая ам.доллараар, ханшийн зөрүүгээр 791 сая ам.доллараар тус тус өөрчлөгдсөн байна.

Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 54%-ийг буюу 8,851 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 46% буюу 7,426 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- БНХАУ-аас 4,700 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 29%,
- Канад улсаас 4,404 сая ам.доллар буюу 27%,
- Хонг Конг улсаас 1,433 сая ам.доллар буюу 9%,
- Сингапур улсаас 1,322 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 8%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтуудыг тус тус хийсэн байна.

Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2016 оны эцэст 280 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 26%-иар, харин гадаад пассивын үлдэгдэл 3,631 сая ам.долларт хүрч 18%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


Актив: эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл, Гонг конг 63%, Австрали 11%, АНУ 7%, Сингапур 6%, улс тус тус 1%-ийг эзэлж байна.

Пассив: эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал, Сингапур 22%, Гонг конг 15%, Япон 5%, бусад улс 21%, харин 40% нь эзэмшигч тодорхойгүй буюу хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа үнэт цаас эзэлж байна.


Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2015	12/31/2016	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-28,632	-29,353	721	3%
I. Гадаад актив	3,907	4,309	402	10%
1. Шууд хөрөнгө оруулалт	440	455	16	4%
2. Багцын хөрөнгө оруулалт	223	280	57	26%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	114	100	-14	-12%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,807	2,178	370	20%
5. Нөөц актив	1,323	1,296	-27	-2%
II. Гадаад пассив	32,539	33,662	1123	3%
1. Шууд хөрөнгө оруулалт	20,696	16,277	-4419	-21%
2. Багцын хөрөнгө оруулалт	3,067	3,631	564	18%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	166	116	-50	-30%
4. Бусад хөрөнгө оруулалт	8,610	13,638	5028	58%


Дүрслэл 6. Гадаад актив



Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2016 оны эцэст



Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2016 оны эцэст



III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2016 оны эцсийн байдлаар 24,625 сая ам.долларт хүрч өмнөх оны эцсийн гүйцэтгэлээс 1,907 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 1,109 сая ам.доллараар нэмэгдэж 4,869 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 169 сая ам.доллараар буурч 1,791 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд 2016 онд нийтдээ 966.8 сая ам.доллараар өсч 17,965 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2016 оны эцэст 2,417 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 14%-иар буюу 289 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 45%-ийг урт хугацаат зээл, 25%-ийг бонд өрийн бичиг, 19%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 10%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат зээлийн үлдэгдэл харгалзан 1,948 сая ам.доллар, 469 сая ам.долларт хүрээд байна.

Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2016 оны эцэст 15,548 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 678 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 48% буюу 7,426 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.


Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл 2016 оны эцсийн байдлаар 216 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)


Үзүүлэлт	12/31/2015	12/31/2016	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	22,718	24,625	1,907	8%	100%
I. Засгийн газар	3,760	4,869	1,109	29%	20%
II. Төв банк	1,960	1,791	-169	-9%	7%
III. Банк	2,129	2,417	289	14%	10%
Богино хугацаат	407	469	62	15%	2%
Урт хугацаат	1,721	1,948	227	13%	8%
IV. Бусад сектор	3,749	8,121	4,373	117%	33%
Богино хугацаат	326	394	68	21%	2%
Урт хугацаат	3,423	7,727	4,304	126%	31%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	11,121	7,426	-3,695	-33%	30%

*: Нийт өсөлтөд оруулсан хувь

Дүрслэл 9. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 10. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	Он			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2014	2015	2016	Дүн	2015/14	Дүн	2016/15
I. УРСГАЛ ДАНС	-1934	-948	-700	986	-51%	249	26%
Бараа ба үйлчилгээний худалдаа	-1,111	-153	0	959	-86%	152	100%
Кредит	6,078	5,135	5,605	-943	-16%	470	9%
Дебет	7,189	5,288	5,605	-1,901	-26%	317	6%
1. Бараа	178	563	1,338	385	217%	775	138%
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	5,471	4,446	4,804	-1,024	-19%	358	8%
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	5,293	3,884	3,466	-1,409	-27%	-418	-11%
2. Үйлчилгээ	-1,289	-715	-1,338	574	-45%	-623	-87%
Кредит	607	689	801	82	13%	112	16%
Дебет	1,896	1,404	2,139	-492	-26%	735	52%
2.1 Тээвэр	-190	-106	-176	84	-44%	-70	-66%
Кредит	204	239	255	34	17%	17	7%
Дебет	394	345	431	-50	-13%	87	25%
2.2 Аялал	-258	-176	-166	82	-32%	10	6%
Кредит	215	246	316	31	14%	71	29%
Дебет	473	422	482	-51	-11%	61	14%
2.3 Бусад үйлчилгээ	-841	-433	-996	408	-49%	-563	-130%
Кредит	188	205	229	17	9%	25	12%
Дебет	1,029	638	1,225	-391	-38%	587	92%
3. Анхдагч орлого	-973	-970	-911	3	0%	58	6%
Кредит	57	59	68	2	3%	9	16%
Дебет	1,030	1,028	980	-1	0%	-49	-5%
3.1 Ажилчдын цалин	-113	-42	-28	70	-62%	14	34%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-860	-927	-883	-67	8%	44	5%
3.3 Бусад	0	0	0	0	0%	0	0%
4. Хоёрдогч орлого	150	174	212	24	16%	38	22%
Кредит	333	320	305	-12	-4%	-16	-5%
Дебет	183	146	93	-37	-20%	-54	-37%
үүнээс: Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	35	26	56	-9	-26%	31	119%
Бусад байгууллага	115	148	156	34	29%	7	5%
II. ХӨРӨНГИЙН ДАНС	136	116	91	-20	-15%	-25	-22%
1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (Дт/ бууралт (Кр))	0	0	0	0	0%	0	0%
Кредит	0	0	0	0	0%	0	0%
Дебет	0	0	0	0	0%	0	0%
2. Хөрөнгийн шилжүүлэг	136	116	91	-20	-15%	-25	-22%
Кредит	136	117	94	-20	-14%	-23	-20%
Дебет	1	1	3	0	33%	2	152%
Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-1,799	-833	-609	966	-54%	224	27%
III. САНХҮҮГИЙН ДАНС	-1504	-788	-812	716	-48%	-24	-3%
Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-1,504	-788	-812	716	-48%	-24	-3%
1. Шууд хөрөнгө оруулалт	-231	-83	4,171	148	-64%	4,254	5131%
1.1 Актив	107	11	14	-96	-89%	3	27%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	104	10	14	-94	-90%	4	43%
1.1.2 Өрийн хэрэгсэл	3	1	0	-1	-53%	-1	-100%
1.2 Пассив	338	94	-4,156	-243	-72%	-4,251	-4507%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-26	95	-399	122	-459%	-494	-519%
1.2.2 Өрийн хэрэгсэл	364	-1	-3,758	-365	-100%	-3,757	-483935%
2. Багцын хөрөнгө оруулалт	-270	-248	-487	21	-8%	-239	-96%
2.1 Актив	41	29	13	-13	-30%	-16	-55%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	38	34	1	-4	-10%	-33	-98%
2.1.2 Өрийн бичиг	4	-5	12	-9	-243%	18	335%
2.2 Пассив	311	277	500	-34	-11%	223	80%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-3	0	4	3	-102%	4	7232%
2.2.2 Өрийн бичиг	315	277	496	-37	-12%	219	79%
2.2.2.1 Богино хугацаат	0	0	0	0	0%	0	0%
2.2.2.2 Урт хугацаат	315	277	496	-37	-12%	219	79%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	-1	-1	38	0	23%	39	0%
3.1 Актив	3	-1	-12	-4	-125%	-12	0%
3.2 Пассив	4	1	-50	-4	-88%	-51	0%
4. Бусад хөрөнгө оруулалт	-1,002	-455	-4,534	547	-55%	-4,079	-896%
4.1 Актив	306	233	419	-73	-24%	185	79%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0	0%	0	0%
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	227	237	327	10	4%	91	38%
4.1.3 Зээл	46	2	10	-44	-97%	8	538%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0	0%	0	0%
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	34	-5	82	-39	-114%	87	1784%
4.1.5.1 Богино хугацаат	34	-5	82	-39	-114%	87	1784%
4.1.5.2 Урт хугацаат	0	0	0	0	0%	0	0%
4.1.6 Бусад авлага	0	0	0	0	0%	0	0%
4.2 Пассив	1,308	689	4,953	-620	-47%	4,264	619%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0	0%	0	0%
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	471	454	123	-17	-4%	-331	-73%
4.2.3 Зээл	751	349	4,968	-402	-54%	4,619	1323%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0	-100%	0	0%
4.2.3.2 Хадгаламжийн байгууллагууд	259	182	229	-77	-30%	46	25%
4.2.3.3.1 Богино хугацаат	93	55	53	-38	-41%	-2	-4%
4.2.3.3.2 Урт хугацаат	166	127	176	-39	-23%	49	38%
4.2.3.3 Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	139	189	571	50	36%	382	202%
4.2.3.4 Бусад салбар	352	-22	4,169	-374	-106%	4,191	19124%
4.2.3.4.1 Богино хугацаат	-78	-65	-77	14	-18%	-12	-19%
4.2.3.4.2 Урт хугацаат	431	43	4,246	-388	-90%	4,203	9865%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0	0%	0	0%
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	38	-186	-139	-225	-585%	47	25%
4.2.5.1 Богино хугацаат	38	-186	-19	-225	-585%	167	90%
4.2.5.2 Урт хугацаат	0	0	-120	0	0%	-120	0%
4.2.6 Бусад авлага	48	72	0	24	50%	-72	0%
4.2.7 Зээлжих тусгай эрх /Урт хугацаат/	0	0	0	0	0%	0	0%
IV. Алдаа болон орхигдуулга	-176	-223	-221	-47	27%	2	1%
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-471	-268	-18	203	-43%	250	93%
V. НӨӨЦ ХӨРӨНГӨ	-471	-268	-18	203	-93%	250	93%
1. ГВУН	-533	-271	-18	262	-93%	253	93%
2. ОУВС-гийн зээл	-62	-3	0	59	-100%	3	100%
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0	0%	0	0%

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2010	12/31/2011	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015	12/31/2016
Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц	(6,489)	(12,314)	(19,238)	(24,642)	(27,230)	(28,632)	(29,353)
Актив	6,221	6,127	6,753	4,340	4,045	3,907	4,309
Шууд хөрөнгө оруулалт	2,616	1,757	883	351	427	440	455
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	2,595	1,704	817	282	355	366	380
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	2,595	1,704	817	282	355	366	380
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бус бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяалал тодорхойгүй бол	0	0	0	0	0	0	0
үүнээс: Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн хэрэгсэл	20	54	66	69	72	73	75
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	20	54	66	69	71	72	75
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	1	1	1
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бус бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяалал тодорхойгүй бол	0	0	0	0	0	0	0
үүнээс: Өрийн бичиг	0	0	0	0	0	0	0
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	0	0	0	0	0	0	0
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бус бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяалал тодорхойгүй бол	0	0	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	359	202	485	370	217	223	280
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	308	196	479	365	208	213	259
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	0	3	2	3	3
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	308	196	479	362	206	210	256
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	51	6	6	6	9	10	21
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	0	0	0	6	17
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	51	6	6	6	9	4	4
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	0	1	0	49	121	114	100
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	1	0	49	121	114	100
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	959	1,318	1,259	1,404	1,630	1,807	2,178
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	839	1,033	896	1,100	1,225	1,443	1,746
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	503	500	530	489	311	441	762
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	335	533	366	611	913	1,002	984
Зээл	18	14	15	6	49	50	62
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	18	9	15	2	47	49	61
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	5	0	3	2	1	1
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	101	271	348	298	357	314	370
Бусад дансны авлага/өглөг	0	0	0	0	0	0	0
Нөөц хөрөнгө	2,288	2,847	4,126	2,166	1,650	1,323	1,296

Эх сурвалж: Монголбанк

Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2010	12/31/2011	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015	12/31/2016
Өр төлбөр	12,711	18,440	25,991	28,981	31,275	32,539	33,662
Шууд хөрөнгө оруулалт	8,445	13,333	17,668	19,579	20,247	20,696	16,277
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	5,459	7,380	8,641	8,989	9,206	9,575	8,851
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	5,459	7,380	8,641	8,989	9,206	9,575	8,851
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бус бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяалал тодорхойгүй бол	0	0	0	0	0	0	0
үүнээс: Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн хэрэгсэл	2,986	5,953	9,028	10,590	11,041	11,121	7,426
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	2,986	5,953	9,028	10,590	11,041	11,121	7,426
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бус бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяалал тодорхойгүй бол	0	0	0	0	0	0	0
үүнээс: Өрийн бичиг	0	0	0	0	0	0	0
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	0	0	0	0	0	0	0
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бус бол	0	0	0	0	0	0	0
хэрэв толгой компани эдийн засгийн харьяалал тодорхойгүй бол	0	0	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	487	564	2,895	2,494	2,877	3,067	3,631
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	124	151	140	114	94	80	71
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	11	11	11	11	11	11	11
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	113	140	129	103	83	69	60
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0
Бүртгэлтэй	0	0	0	0	0	0	0
Бүртгэлгүй	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	364	413	2,755	2,380	2,783	2,987	3,560
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	242	258	547	400	522	652	611
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	114	127	1,587	1,415	1,403	1,473	2,064
Бусад салбарууд	8	28	621	565	858	862	886
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	0	1	0	49	124	166	116
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	1	0	49	124	166	116
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	3,779	4,542	5,427	6,859	8,027	8,610	13,638
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	35	130	480	1,151	1,590	1,954	1,965
Төв банк	0	0	337	990	1,449	1,772	1,725
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	35	130	143	161	141	182	240
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0
Зээл	3,564	4,063	4,559	5,275	5,965	6,398	11,457
Төв банк	274	268	235	141	73	68	65
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	235	352	486	815	1,100	1,294	1,567
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	1,769	1,917	2,012	2,119	2,098	2,287	2,805
Бусад салбарууд	1,287	1,526	1,826	2,200	2,694	2,749	7,020
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	180	350	389	433	424	138	216
Бусад дансны авлага/өглөг	0	0	0	0	48	120	0

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2010	12/31/2011	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015	12/30/2016
Засгийн газар	1,882.2	2,043.3	3,599.3	3,534.6	3,500.8	3,759.9	4,868.6
Төвбанк	273.6	267.7	571.5	1,130.5	1,570.4	1,959.6	1,790.8
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	512.0	739.8	1,176.0	1,375.8	1,762.2	2,128.5	2,417.4
Бусад салбарууд	1,474.3	1,904.7	2,836.1	3,198.7	3,976.6	3,748.9	8,121.5
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	2,985.7	5,952.8	9,027.6	10,590.1	11,040.6	11,120.9	7,426.3
Нийт гадаад өр	7,127.8	10,908.3	17,210.5	19,829.7	21,850.5	22,717.8	24,624.5